



## БАЙГАЛИЙН БАЯЛАГИЙН ХАРААЛ БА МОНГОЛ<sup>1</sup>

Илтгэгч: Батаагийн Эрдэнэбат

*Эрдэм шинжилгээний ахлах мэргэжилтэн,  
Эдийн Засгийн Тэнхим, Ланкастерын Их  
Сургуулийн Менежментийн Сургууль*

*Монгол минь чи хаашаа л яваад байна даа?*

### Товч Хураангуй

Уламжлалт эдийн засгийн онол болон аж үйлдвэржилтийн хувьсгалын түүхээс аливаа үндэстэн баялаг ихтэй байх тусмаа хурдацтай хөгжих зүй тогтол харагддаг. Үнэхээр ч Америк, Канад, Англи, Норвеги улсуудын хөгжил цэцэглэлтийн нэг тулгуур нь арвин их ашигт малтмалын ордууд нь байсан билээ. Гэвч бидний хувьд харамсалтай, цаашилбал сэтгэл зовоосон “байгалийн баялагийн хараал” хэмээх үзэгдэл 1990-ээд оноос хойш олон нийтийн анхаарлыг ихээр татах болжээ. Энэхүү нийтлэлд энэ үзэгдэл юунаас үүдэлтэй юм, Монгол улсад энэ нь хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлаж, бид яах вэ гэдэг талаар санал бодлоо дэвшүүлж байна.

### Оршил

Сүүлийн 30 гаруй жилд ямар ч байгалийн баялаггүй улсууд, жишээ нь, Азийн бар гэгдэх Сингапур, Өмнөд Солонгос, Тайван, Хонг Конг үсрэнгүй хөгжиж байхад арвин их нөөц баялагтай Африк, Латин Америк, Ойрх Дорнодын улсуудын эдийн засаг нь туйлын чамлалттай өсөж, тэр ч бүү хэл, доройтох болсон билээ. Энэхүү үзэгдлийг “байгалийн баялагийн хараал” хэмээн нэрлэдэг. Энэхүү “хараал” ёсоор өнөөгийн даяаршлагдсан эринд аливаа улсын эдийн засаг хэдий хэмжээгээр түүхий эд, тэр тусмаа олборлох салбараас хамааралтай байна төдий хэмжээгээр эдийн засгийнх нь хэтийн төлөв бүрхэг болдог гэдэг. Гэхдээ энэхүү үзэгдлийг нийтээр хүлээн зөвшөөрдөггүйг дурдах хэрэгтэй. Эсэргүүцэгчдийн гол санаа нь эдийн засгийн бодлого муутай улсуудад олборлох салбараас өөр салбарууд оршин тогтнох боломж бүрддэггүй. Гол буруутан нь тэгэхлээр баялаг бус эдийн засгийн буруу бодлого, цаашилбал институцүүдийнх нь дорой чадавхи юм гэж үздэг. Байгалийн баялагийн хараал үнэн ч бай, худал ч бай, 2008 оны байдлаар нийт экспортынхоо 84% (1992 онд 50.2% байсан), дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ (ДНБ) 28% (1996 онд 10.4% байсан) орчимыг олборлох салбараас олж буй манай улсын хувьд энэхүү асуудалд нухацтай хандах цаг болжээ.[1]

Энэхүү нийтлэлийг би Монгол улсын өнөөгийн болон ирээдүйн эдийн засагт байгалийн баялаг ямар уршиг дагуулж болохыг тайлбарлаж, үүнээс сэргийлэх арга хэмжээнүүдийн талаар Монголчууд бид бүгдээрээ хэлэлцэж эхлээсэй хэмээн найдаж бичлээ.


Нийтлэлийн 1-р хэсэгт байгалийн баялагийн хараал гэж юу болох талаар, удаах хэсэгт энэ үзэгдэл юунаас болж үүсээд байгааг, 3-р хэсэгт энэ нь Монгол улсад ямар байдлаар илэрч байгааг, төгсгөл хэсэгт дэлхийн шилдэг эдийн засагчид болон нийгмийн зүтгэлтнүүдийн зүгээс буурай хөгжилтэй бөгөөд байгалийн баялагаас асар их хараат улсуудад өгч буй зөвлөмжүүдийг дурдаж мөн өөрийн санал бодлоо илэрхийлэх болно.

### 1. Байгалийн баялагийн хараал гэж юу вэ?

Байгалийн баялагийн хараал гэж өнөөгийн даяаршсан ертөнцөд байгалийн арвин их баялагтай улсууд түүнийгээ улс орныхоо эдийн засгийн хөгжил, цаашилбал хүн амынхаа амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд ашиглаж чадахгүй байгаа үзэгдлийг нэрлэдэг.

Зураг 1. Байгалийн баялагаас хараат байдал болон эдийн засгийн өсөлт


<sup>1</sup> Энэхүү өгүүлэлийг бичих явцад тоо материал, санал бодолоо хуваалцсан Сандуйжавын Дэлбадрах, Reyer Gerlagh, Bernard Walters нарт талархсанаа илэрхийлье.



Түүхий эдийн экспортын ҮНБ-д эзлэх хувь (1970)

Зураг 1 энэхүү үзэгдлийг дүрслэн харуулж байна. Энд тоо баримт нь найдвартай дэлхийн 87<sup>2</sup> орны 1970 оны Үндэсний Нийт Бүтээгдэхүүнд (ҮНБ) эзлэх байгалийн баялагийн экспортын хувь болон 1965-1990 оны Дотоодын Нийт Бүтээгдэхүүнийх (ДНБ) нь дундаж өсөлтийн хурдын хоорондын хамаарлыг харуулж байна.<sup>3</sup> Зураг дээрх цэг болгон нэг улсыг төлөөлж байгаа бөгөөд байгалийн баялагаас хараат байх тусам эдийн засгийн өсөлт нь сул, олон тохиолдолд бүр агшиж байсныг харж болно. Энэхүү гайхал төрүүлэм баримт өдгөө хөгжлийн эдийн засагчдын хамгийн их сонирхол татсан асуудал болжээ.

Зураг 2. Нэг Хүнд Ногдох ДНБ (2005 оны ХУЧП-аарх Ам.\$)



Эх үүсвэр: Дэлхийн Банк, Дэлхийн Хөгжлийн Үзүүлэлтүүд, (World Development Indicators, various issues) Reyer Gerlagh-ийн цуглуулсан тоо баримт. Зурагт хоорондын зөрөөг харьцуулахын тулд нэг хүнд ногдох ДНБ-ээс логарифм авсан болно.<sup>4</sup>


Тэдний гаргасан дүгнэлтээр энэхүү сөрөг хамаарал (зурагт шулуун шугамаар дүрслэгдсэн) нь статистикийн хувьд хүчинтэй, нэлээн тогтвортой аж. Уг хамаарал зөвхөн энэ хугацаанд ч бус сүүлийн үеийн тоо баримтын хувьд ч хүчинтэй [3], байгалийн баялагийн экспортоос хараат бус улсуудыг нь хасвал бүр л их хүчтэй [4], мөн бидэнтэй хамт шилжилт хийсэн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн улсууд, зүүн Европын улсууд [5] болон дэлхийн хамгийн хүчирхэг улс гэгдэх АНУ-ын доторх мужуудыг авч үзсэн ч мөн л ажиглагдаж байх аж [6]. Жишээ нь, ОПЕК буюу Газрын Тос Олборлогч Улсуудын Нийгэмлэгийн гишүүн улсуудын нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт нь 1965-1998 оны хооронд өсөх биш харин ч жилд дунджаар 1.3% аар буурч [7], асар том нефтийн олборлох салбартай Венесуэл улсад энэхүү баялаг нь байхгүй байсан бол “хараал” хүрэлгүй, нэг хүнд ногдох ДНБ нь 14%-аар өндөр байх байсан ажээ [4]. Нөгөө талаас үүний эсрэг гарсан арай сүүлийн үеийн үзлээр [8] байгалийн баялагаас хараат байна гэдэг нь анхдагч бус, Засгийн Газрынх нь арчаагүй бодлого анхдагч юм. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн бодлого буруу үед олборлох салбараас нь өөр ямар ч салбар оршин тогтнох боломжгүй гэж үздэг.

<sup>2</sup> Хуучин ЗХУ болон бусад социалист блокын улсуудыг оруулаагүй болно. Mehlum et al. (2006)-ын тоо баримтын анхдагч эх үүсвэр нь <http://www.earth.columbia.edu/sitefiles/File/about/director/documents/Africa.xls>. Хуучин социалист системийн улсуудын хувьд үүнтэй тоо баримтыг Kronberg (2004) цуглуулсан байгаа.

<sup>3</sup> ДНБ, ҮНБ хоёулаа аливаа улсын эдийн засаг нэг жилийн дотор бүтээн бий болгосон бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт үнийн нийлбэрийг хэмждэг. Эхнийх нь, жишээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бий болсон баялагийг хэмждэг бол сүүлийнх нь нутагтаа төдийгүй гадаадад Монголчуудын бий болгосон баялагийг хэмждэг. Энэ 2 үзүүлэлтийн нэг хүнд ногдох хэмжээ өндөр байх тусам хүн амын амжиргааны түвшин дээшлэх боломж сайжирч байдаг.

<sup>4</sup> Улсуудын ДНБ-ийг 2005 оны Америк доллар-руу эхлээд хөрвүүлсэн. Нэгэнгт 1 Ам. Доллараар худалдан авах бараа үйлчилгээ улс бүрт ондоо байдаг учир тэдгээрийг Худалдан Авах Чадварын Паритет (ХУЧП) гэдэг зүйлийг ашиглан хооронд нь харьцуулах боломжтой болгодог.

Зураг 3. ДНБ-ий өсөлт (5 жилийн жигнэсэн дундаж %)



ДНБ-ний жилийн өсөлт. 5 жилийн жигнэсэн дундажийг гаргахад 0.33, 0.77, 1, 0.77, 0.33 гэсэн коэффициентүүд ашиглав. Эх үүсвэр дээрх зурагийнхтай ижил.

Бодлогын салбарт энэхүү асуудал мөн л асар их анхаарал татаж байна. Олон улсын тусламжийн байгууллага болох Oxfam [9] хөгжиж байгаа улсуудад олборлох үйлдвэрлэлийг дэмжихгүй байхыг хөгжингүй улсуудын Засгийн Газрууд, Олон улсын байгууллагуудад уриалж, Дэлхийн Банкнаас санхүүжүүлж бие даасан судлаачдаар хийлгэсэн Олборлох Салбарын Тоймд [10] олон улсын санхүүгийн байгууллагууд 2008 он гэхэд гишүүн орнууд дахь шингэн түлшний төслүүдэд олгох зээлийг зогсоож бусад олборлох салбаруудын зээлийг хязгаарлахыг зөвлөж байсан. Үүний дараахан нь харин тухайн банкны удирдлагаас хийлгэсэн хэвлэлийн бага хурлаас уг зөвлөмжийн дүгнэлтийг үгүйсгэж “удирдлага ... газрын тос, байгалийн хий, олборлох үйлдвэрүүдэд оруулах хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлэх бөгөөд эдгээр нь олон ядуу улсуудын хөгжлийн чухал хэсэг юм” хэмээжээ [11].

Энэ нь бидний хувьд юу гэсэн үг вэ? Юуны өмнө хэрэв энэхүү байгалийн баялагийн хараал үнэн бол бид уул уурхайд тулгуурласан эдийн засгийн өнөөгийн тогтолцоогоо эргэн харах хэрэгтэй гэсэн үг юм. Жишээ нь Зураг 1-т Монгол улсыг оруулбал Монгол Улсын түүхий эдээс хараат байгаа байдал 36% буюу энэхүү графикт дүрслэгдсэн 87 улсаас зөвхөн дайн дажин, үймээн самуунаас салдаггүй Африкийн улсууд болох Замби, Гайана, Гамби улсуудаас л арай дээр байна. Мэдээж Монгол Улсын тоо зөвхөн 12 жилийн үзүүлэлтэд тулгуурласан бол бусад улсынх даруй гурав дахин урт хугацааны хамаарлыг харуулж байгаа. Гэвч Оюу Толгой болон бусад томоохон ордуудыг шавхан дуусах 30 гаруй жилийн дараа Монгол Улс бусад аль ч улсаас илүү түүхий эдийн бааз болон хувирсан байх бизээ. Цаашилбал нэгэнт бид түүхий эдээс улам их хамааралтай болох тусам эдийн засгийн өсөлт хумигдах учир 1997-2008 оны дундаж өсөлт болох жилийн 6% сөрөг болохын тулд бидний өмнө он удаан жилийн эдийн засгийн доройтол нүүрэлж байна гэсэн үг болно. Зураг 2, 3- ч үүнийг л зөгнөх аж. Зураг 2-т нэг хүнд ногдох ДНБ 1960-2006 онд хэрхэн өөрчлөгдөж ирсэнийг харуулж байна. 1970-аад оны эхнээс 90-ээд оны эхэн хүртэл дэлхийн бүх улсууд, тэр дотроо ямар ч байгалийн баялаггүй ядуу улсууд өсөж байхад зөвхөн байгалийн баялагаа зарж иддэг улсууд улам бүр доройтон буурч байсныг харж болно. Зураг 3-аас байгалийн баялагтаа дулдуйдагч улсууд дэлхийн эдийн засгийн уналтад хамгийн эмзэг, хямралд байх хугацаа нь хамгийн урт байгааг харж болно.

Бид үнэхээр ийм ирээдүй рүү тэмүүлж байгаа гэж үү? Энэхүү асуултанд хариулахын өмнө яагаад байгалийн баялаг өнөөдөр тэр бүр эдийн засгийн өсөлт дагуулахгүй байгааг сонирхоё.

## 2. Энэ бүхэн юунаас үүдэлтэй юм бэ?

Байгалийн баялаг эдийн засагт дор хаяж дараах зургаан сувгаар сөрөг нөлөө үзүүлж болно гэж үздэг.

**2.1. Голланд өвчин<sup>5</sup>.** Аливаа улс байгалийн нөөц олж, олборлож, олон улсын зах зээл дээр гадаад валютаар зарж түүнийгээ хэрэглээндээ зарцуулж эхэлснээс дотоод валютынх нь ханш чангарч, импортын бараа бүтээгдэхүүн дотоод үйлдвэрийнхээс нь харьцангуй хямд болсноор өөрсдийн үйлдвэрүүд нь хаагдаж эхэлдэг. Түүнчлэн олборлох салбарын цалин болон хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшин бусад салбаруудынхаасаа харьцангуй өндөр болж тэдгээрийн чадварлаг боловсон хүчин болон зээлийн капиталыг өөртөө татах болсноор гадаад өрсөлдөгчидтэйгөө байнга өртөг зардлын хувьд өрсөлдөж байдаг хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн салбар улам доройтдог. Хэрэв баялагийнх нь олон улсын зах зээл дээрх үнэ унах юм уу, тэрхүү баялагаа олборлож дуусмагц эдийн засгийг нь авч явах ямар ч салбаргүй болж хоцорсон байх болно. Мөн аж үйлдвэрийн нэг салбарт гарсан дэвшилтэт технологи, ажиллах хүчний чадавхижилт бусад салбарууддаа тархаж байдаг бол бусад салбаруудаас орон зайн болон, бизнесийн хэлхээ холбооны хувьд нэлээн салангид олборлох салбар бусад салбаруудаас энэ талаар таслагдмал, зөвхөн өөрийн багахан, алслагдсан, хязгаарлагдмал хүрээнд л үр ашгаа өгч байдаг [4]. Нөгөө талаас энэ үед дотоод компаниуддаа лоббидуулсан Засгийн газар Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих нэрийдлээр чөлөөт худалдааг боогдуулж, импортын тарифын болон тарифын бус хориг тогтоовол

<sup>5</sup> Энэ нэр 1970-аад онд Голланд Хойд тэнгист байгалийн хий олж, олборлож эхэлснээс болж бусад эдийн засгийн салбаруудынх нь уналтаас үүдэн гарсан бөгөөд хэдийгээр тэд үүнийгээ богино хугацаанд залруулсан ч энэхүү муу нэр нь хэвшил болон үлдичжээ.

Голланд өвчний энэхүү шууд бус лобби нөлөөлөл нь эргээд нийт эдийн засгийн үр ашгийг муутгаж, өсөлтийг нь бас бууруулах болно.

**2.2. Нөөцийн орлогын хувьсамтгай байдал.** Байгалийн баялагаас орж ирэх орлого хувьсамтгай байдлаараа алдартай. Гэтэл энэхүү хувьсамтгай байдал нь эдийн засгийн урт хугацааны төлөвлөлт, хөрөнгө оруулалт хийх боломжийг хязгаарлаж, хэрэгжсэн ч эх үүсвэрийн тасалдлаас болж үр ашиг нь төлөвлөснөөс доогуур байхад хүргэдэг. Үүнээс нь ч үндэслэн ихэнх тохиолдолд нөөцөөс орж ирэх мөнгө хөрөнгө оруулалт бус хэрэглээнд зарцуулагддаг [12]. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг энэхүү эх үүсвэрээс санхүүжүүлэх нь цаашаа бас дам хор уршигтай. Хэрэв санхүүгийн эх үүсвэрийн доголдлоос болж төр аmlарсан үйлчилгээг үзүүлж чадахгүй бол түүнд итгэх итгэл алдарч, түүнтэй хамт хуулиа дээдлэх, иргэд болон байгууллага хоорондоо хийсэн гэрээ хэлцэлээ хүндэтгэхгүй болох муу талтай байдаг. Эдгээр нь тэгтэл амжилттай эдийн засаг бүрэлдэн тогтох наад захын шаардлага юм. Орлогын хувьсамтгай, тодорхой бус байдал дараах эх үүсвэрүүдтэй:

- Олборлох салбарын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ асар их хэлбэлзэлтэй байдаг.
- Аливаа ордын ашиглалтын хурд байнга өөрчлөгдөж, түүнтэй холбоотой эдийн засагт орж ирэх орлого ч мөн өөрчлөгдөж байдаг. Технологийн шинж чанартай ашиглалтын хурд өөрчлөгдөхөөс гадна, тухайн орны дотоод улс төрийн хямрал мөн үүнд нөлөөлж байдаг.
- Дээрх хоёр эх үүсвэрээс гадна олборлогч болон Засгийн газрын хоорондох татварын болон бусад гэрээ тохиролцооны улмаас татварын амралт, хөнгөлөлт, чөлөөлөлт мөн орлогын тогтворгүй байдлын эх үүсвэр болно гэж үздэг.

Орлогын хувьсамтгай байдлаас хамгаалах зорилгоор Засгийн Газрууд “Хөрөнгө Оруулалтын”, “Тогтворжуулах” гэх мэт сангууд байгуулахыг зорих нь элбэг. Норвегийн Тогтворжуулах Сан, Аляскагийн Хөгжлийн Сангууд эдгээрийн үлгэр дуурайлал нь болдог. Гэтэл тогтворгүй эх үүсвэрээр урт хугацааны эдийн засгийн үр өгөөжтэй, тогтвортой хөрөнгө оруулалт хийнэ гэдэг амар зүйл биш. Нэгдүгээрт уг санг байгуулахад урьдчилаад хяналт шалгалтын болон мэргэжлийн өндөр чадавхи бүхий удирдлагын тогтолцоо шаардлагатай. Ихэнх хөгжиж буй, байгалийн баялагаасаа хараат улсуудад ийм институцүүд байдаггүй. Хоёдугаарт, хэзээ нөөцөөс орж ирэх орлогыг хуримтлуулж, хэзээ хэрэглэхийг шийдэх нь хэн бүхэнд тодорхойгүй.

Тухайлбал, хэрэв нөөцийн үнэ ямар нэгэн түвшнээс дээш гарсан тохиолдолд хуримтлуулж, түүнээс доош унасан үед хэрэглэнэ гэсэн дүрэмтэй байлаа гэхэд нэгэнт энэхүү түвшинг байнга хувьсан өөрчлөгдөж байгаа олон улсын зах зээлтэй уялдуулан оновчтой тогтооход хэцүүн улмаас үе үеийн засгийн эрх баригчид өөрсөддөө таалагдсан түшин тогтоохийг зорих болно [13].

Тодорхой хууль эрх зүй, ёс зүй, хяналтын тогтолцоо бүрэлдээгүй үед бүх талын намууд энэхүү санг нийтээрээ дэмжиж, тусгаар тогтнол, тогтвортой үйл ажиллагааг нь хангаж ажиллуулахын оронд Засгийн эрхэнд гарсан намууд нь өөрсдийн эзэлсэн байр суурийг тогтворжуулах, ирээдүйн өрсөлдөгчиддөө улс төрийн бэлэн хоол үлдээхгүйн тулд эрх барих хугацаандаа тонон, шавхан хэрэглэх сонирхолд автах нь олонтаа. Нөгөө талаас зарим улсууд олон улсын санхүүгийн зах зээл дээрээс нөөцийн үнийн өөрчлөлтөөс хамгаалах даатгал худалдан авахыг оролддог. Харамсалтай нь, энэхүү даатгалын хэлбэр нь хугацааны хувьд урт байх нь ховор бөгөөд, байсан ч тухайн улсдаа алдагдалтай байх нь олонтаа. Тухайлбал сүүлийн үед бидний жишээ авах ёстой гээд байгаа Чили улсын төрийн өмчийн Коделко компани 1993.11-1994.01 хугацаанд фючерсийн зах зээл дээр 178 сая америк доллар алдсан байдаг [14]. Өнөөгийн дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямрал байгалийн баялагаа зарж орлогыг нь хөрөнгө оруулалтын сангуудад хадгалах бус газрийн хэвлийд нь байлгавал хавьгүй эрсдэл багатай байж болохыг мөн харуулах мэт.

**2.3. Олборлох салбарын хэт их ашиг буюу “рент”, түүний институцүүдэд үзүүлэх нөлөө.**<sup>6 7</sup> Сүүлийн үед хамгийн их анхаарал татах болсон асуудал нь олборлох салбарын хэт их ашиг буюу “рент” байгалийн баялагт тулгуурлагч улсуудын институцүүдийнх нь тусгаар тогтнол, тогтвортой байдал, цаашдийн хөгжилд заналхийлж байгаа явдал юм.<sup>8</sup> Үүний нөлөө дараах хэлбэрүүдээр илэрдэг:

- **Авилгал.** Рентийн хамгийн уршигт үр дагавар нь нийгмийн бүхий л давхаргыг хамарсан авилгал, хээл хаууль, ёс суртахууны доройтол юм. Байгалийн арвин их баялаг болон авилгалын хоорондох эерэг хамаарлыг баталгаажуулсан эмпирик болон онолын судалгаанууд ч хангалттай байна [15,16].<sup>9</sup> Дотоод ч бай, гадаад ч бай аливаа олборлогч компаниудын ашиг олох хамгийн эхний алхам нь нөөцийг зах зээлийн ханшаас нь аль болох доогуур авах явдал байдаг. Хяналт, ил тод байдал сул, шударгаар өрсөлдөх боломж хаагдмал үед энэ нь төрийн эрх мэдэлтнүүдэд төрөл бүрийн хэлбэрт хахууль өгөх, тэдгээр эрх мэдэлтнүүдэд нөлөөлж байдаг улс төрчдийн сонгуулийн

<sup>6</sup> Хэт их ашиг буюу “рент” гэдэг нь дэлхийн зах зээлийн үнээс олборлох, боловсруулах, хайлуулах, зах зээл рүү тээвэрлэх зардал болон “өрдийн” бизнесийн өгөөжийг хассаны дараах үлдэгдлийг хэлдэг. Зарим тохиолдолд үүнийг хөдөлмөрлөж олоогүй ашиг ч гэдэг.

<sup>7</sup> Институци гэдэг нь өргөн утгатай ойлголт юм. Интэрнэтийн нэвтэрхий толь Wikipedia-д үүнийг хэсэг хүмүүс (жишээ нь нэг гэр бүл эсвэл үндэстэн)-ийн хоорондох харилцааг зохицуулж байдаг дэг журам, механизм, зохион байгуулалт, хамтран ажиллах хэвшлийг хэлнэ хэмээн тодохойлжээ. Энэхүү өгүүлэлд би институци гэдгийг төрийн тогтолцоо, Засгийн газар, олон нийтийн байгууллагууд гэдэг утгаар хэрэглэнэ.

<sup>8</sup> Жишээ нь Ross (2001) Индонезийн өөрсдийнх нь улс төрчид нь хэрхэн Ойн Нөөц Удирдах Агентлагаа системтэйгээр үгүй хийж, ойн нөөцийг нь шавхан барагдуулж хувийн ашиг хонжоо болгосон талаар дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.

<sup>9</sup> Энэхүү баримтыг эсэргүүцэгчид байдгийг дурдах хэрэгтэй. Жишээ нь, Stijns (2005) эдийн өсөлтийг тодорхойлогч бүхий л хүчин зүйлс, тэр тусмаа институцийн чанар, ашигт малтмал биш газрын хэмжээ илүү сөргөөр нөлөөлдөг гэж маргасан байдаг.

сурталчилгаанд нь хандив өгөх зэрэг хэлбэрээр хэрэгждэг<sup>10</sup>. Нэгэнт асар их ашигтай олборлох эрх авчихсан аж ахуйн нэгжүүд тэрхүү эрхийг олгох болсон, түүнийг нь хамгаалж байх эрх мэдэлтнүүдийг байр сууринд нь байлгах, энэхүү байдлыг зогсоох гэсэн аливаа оролдлогыг таслан зогсоохыг оролдох нь ойлгомжтой. Хахууль зөвхөн төрийн албан хаагчид руу чиглэгддэггүй. Асар их санхүүгийн эх үүсвэр дагуулсан албан тушаал эзэмших болон түүнийгээ хадгалж байхын тулд эрх мэдэлтнүүд болон улс төрчид хүн амын тодорхой хэсгийн дэмжлэгийг авч байх хэрэгтэй. Тиймээс тэдэнд зориулж тусгай нийгмийн халамжийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, төрөөс санхүүжүүлсэн шинэ ажлын байр бий болгох мэтийн популист алхамууд байнга хийгдэж байдаг. Үр дүнд нь мэргэжлийн чадвар, ёсзүйгүй, эдийн засгийн үр муутай хэтэрхий том төрийн аппарат, хуваагдмал хүн ам үүсэх аюултай.<sup>11</sup>

- **Эзэмшлийн төлөөх тэмцэлдээн.** Байгалийн баялаг оршиж байгаа орон нутгийн болон төвлөрсөн засаг захиргааны хооронд хэрхэн хувь хүртэх талаар санал зөрөлдөх нь олонтаа. Уугуул нутгийн хүмүүс нь газарт орох, олборлолтоос үүдсэн бохирдолоос болж хохирсныхоо төлөө илүү их хувь хүртэхийг эрмэлзэж байхад нийт хүн ам түүнээс ижил хэмжээгээр хүртэх сонирхолтой байдаг. Үүнээс гадна засаглал дотроо, яам агентлагууд, газруудын хооронд санхүүжүүлтийн эх үүсвэр, захиран зарцуулах эрхийн төлөөх тэмцэлд хүргэж нийт төрийн удирдлагын системээ муутгах аюултай байдаг. Үр дүнд нь байгалийн арвин нөөц болон ардчилсан нийгмийн хөгжилийн хооронд сөрөг хамаарал [17]; зэвсэгт мөргөлдөөн, иргэний дайн гарах магадлалын хооронд эерэг хамаарал байх ажээ [18]. Хэн хүний нүд унагасан эзэмшлээ алдчихгүйн тулд эрх баригчид эдийн засгийн үр ашиггүй асар их зардал гаргаж байдаг. Жишээ нь, байгалийн тос олборлогч улсуудын зэвсэгт хүчин, цагдаагийн зардал бусад улсуудаас 2-10 дахин илүү байдаг [19]. Аливаа улсын институцүүдийн бутралын хамгийн том жишээ нь дайн, иргэний зэвсэгт мөргөлдөөн. Тэгвэл Collier and Hoeffler (2005) байгалийн ямар ч баялаггүй улсад иргэний мөргөлдөөн гарах магадлал нь 0.5% харин байгалийн баялагийн экспорт нь ДНБ-ийх нь 26% эзэлдэг улсад энэхүү магадлал нь 23% гэж тогтоосон байдаг.
- **Төр ард түмний хоорондын холбоо тасрах.** Улс төр-эдийн засгийн онолоор төр, ард түмэн хоёрыг холбогч хамгийн хүчтэй холбоос нь татвар. Ард түмэн татвараа төлж хариуд нь төрийн үйлчилгээг авч байдаг. Нөгөө талаас төр татвараа бүрэн, бага зардалаар хураан авч, оновчтой захиран зарцуулахын тулд цомхон бөгөөд хүчирхэг татварын (төрийн) институц(үүд)тэй байх хэрэгтэй. Энэхүү харилцаа нь төрийн түүхэн хөгжлийн гол түлхүүр гэгддэг. Байгалийн баялагын орлого ихэссэн үед төрд нийт ард түмнээс орж ирэх татварын орлогын ач холбогдол буурч хяналт шалгалт султай байгалийн баялагийн орлогыг илүү эрхэмлэх болно. Нэгэнт харьцангуй бага татвар төлөх болсон ард түмэн төрөө хянаж шалгах эдийн засгийн хөшүүрэггүй болж үр дүнд нь төр ард түмний хоорондох холбоос сулрах, цаашилбал төрийн аппарат хяналт шалгалтгүйн улмаас улам доройтож байдаг [20], [26].

Хүчирхэг институцүүдтэй улсууд харин авилгал, эзэмшлийн төлөөх тэмцэлдээнийг зогсоож, нөөцөөс орж ирэх орлогоо нийт эдийн засгийнхаа шингээх чадварт тохируулан бусад салбарт муу нөлөө үзүүлэхгүйгээр зарцуулан байгалийн баялагаа хөгжлийн түлхүүр болгон ашиглаж болно гэдэг [21],[22]. Жишээ нь, доорх зурагт Зураг 1-т дүрслэгдсэн улсуудаас байгалийн баялагаас хамгийн их хараат 42 улсыг нь ялган авч институцүүдийнх нь чадвараар ангилвал зөвхөн муу институцүүдтэй улсуудад л хараал тусаж байгааг харж болно (ө.х. Зурагийн А хэсэгт ашигт малтмалын экспорт ҮНБ-тэй нь харьцуулахад их байх тусам эдийн засагийн өсөлт нь суларч байхад Зурагийн Б хэсэгт институцийн хөгжил сайн улсуудад тийм статистикийн хувьд хүчинтэй хамаарал байхгүйг харуулж байна).

Энэхүү зурагт нөөцийн экспорт нь 1970 онд ҮНБ-ний 10-аас дээш хувийг эзэлж байсан 42 улсыг институцүүдийнх нь чанараар муу (А хэсэг), сайн (Б хэсэг) гэж ялгаж улс бүрийг цэгээр дүрсэлсэн. Монгол Улсын Институцийн чанарын индекс 2005-2008 онуудад 3.1, 3.13, 3.09, 3.08 ранк нь 96, 105, 120, 121 байсан (индекс өндөр, харин ранк бага байх тусам сайн).



#### Зураг 4. Байгалийн баялагийн хараал ба институцүүдийн чадавхи

А. Муу институцүүдтэй  
улсууд

Б. Сайн институцүүдтэй  
улсууд

<sup>10</sup> Францын шүүхэд өгсөн мэдүүлэгдээ газрын тосны ELF компаний Африк харуулсан менежер "... бүх л олон улсын газрын тосны компаниуд олборлох эрх авахын тулд хахууль өгдөг ш дээ" хэмээн мэдүүлж байсан нь саяхан.

<sup>11</sup> Жишээ нь, Нигезриад 1973-1987 онд төрийн сектороос бусад бүх салбарт ажиллагсадын тоо буурч, Тринадад-Тобагод 1982 он гэхэд төр нийт ажиллах хүчнийхээ 50%-ийг цалинжуулж, цалингийн зардал нь 4 жилийн дотор 4 дахин өссөн байх жишээтэй. Экуадор, Венесуэл, Мексик, Замби гээд олон улс энэхүү алдааг гаргаж байсан.



**2.3. Өрийн хямрал.** Институцүүдийн чадавхи дорой нөхцөлд байгалийн баялаг өрийн хямралд хүргэх нь олонтаа. Мексик, Нигери, Венесуэлын 80 аад оны жишээнээс бид үүнийг харж болно. Нөөцийн олон улсын зах зээл дээрх үнэ бага зэрэг буурахад л нөөцөөс хараат Засгийн газрууд зардлаа танах хэрэгтэй болдог. Гэвч популист бус алхам хийгдэх боломжгүй нөхцөлд энэ нь ихэнх тохиолдолд гаднаас зээл авах замаар санхүүжигддэг. Уул санаа нь нэгэнт л байгалийн баялаг байгаа юм чинь түүнийгээ барьцаалж олон улсын санхүүгийн байгууллагууд, зах зээл дээрээс зээл аваад түүнийгээ дэд бүтэц, хөрөнгө оруулалтад зарцуулах. Зээлдүүлэгчдийн зүгээс муу юм болоход баялагаа зараад зээлээ төлчихнэ гэсэн үндэслэлээр байгалийн баялаггүй улсуудтай харьцуулахад илүү зээл олгох сонирхолтой байдаг<sup>12</sup>. Харамсалтай нь, нэг талаас хэдий хэмжээний зээл, ямар хүүтэйгээр авч, хэр үр ашигтай захиран зарцуулагдаж буйг нь хянаад, удирдаад явах чадалтай институцүүд байдаггүй. Нөгөө талаас олонхи тохиолдолд, зээлийн орлого нөөцийн үнэ харьцангуй өндөр үед орж ирж, дотоод валютынх нь ханшийг чангатган үр ашиггүй хэрэглээнд зарцуулагдах, бүр зориулагдсан төсөлдөө биш хэн нэгний хувийн хөрөнгө болон хувирчихдаг. Дэлхийн эдийн засгийн хямралын үед нөөцийн үнэ шалдаа буучихсан, эсвэл хүүгийн түвшин өссөн үед бүх зээлдүүлэгчид зэрэг зээлээ буцаан татахад зээл авсан улсад нь эргүүлэн төлөх хөрөнгө гаргах нь бүү хэл дахин илүү хөрөнгө шаардлагатай болсон байдаг<sup>13</sup>.

**2.4. Боловсрол, дэд бүтэц дэх хөрөнгө оруулалтын доройтол.** Олон улсуун туршлагаас ажиглагдсан өөр нэг үзэгдэл бол байгалийн нөөц баялаг ихтэй улсуудад боловсрол, дэд бүтцийн хөрөнгө оруулалт дутмаг байдаг явдал юм [23],[24]. Аливаа эдийн засаг олон улсын өрсөлдөөнт зах зээлээс хамааралтай, олон төрөлт эдийн засгийн салбаруудтай үед Төр болон Засгийн газар оршин тогтнохын тулд тэдгээр салбарууддаа ажиллах хүчийг олон улсын түвшинд өрсөлдөхүйц боловсролтой болгох, шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмших боломжоор хангах, дэд бүтэцээ хөгжүүлж, тордож байх шаардлагатай байдаг. Тэгвэл нийт орлогынх нь ихэнх хувийг ажиллах хүчнийх нь өчүүхэн хэсгийг ашиглан, олны нүднээс далд орших олборлолтын салбар оруулдаг улсын Засгийн газрууд энэхүү асуудал дээр сайнаар бодоход санамсаргүй, муугаар бодоход боловсролгүй, дорой ард түмнийг удирдахад хялбар учир назгайрах, хайнга хандах нь даанч олонтаа тохиолдох аж. Энэхүү ужиг нь богино хугацаанд хүчтэй мэдрэгдэхгүй ч урт хугацаанд эдийн засгийн бүтэц нь салбарлаж, төрөлжих боломжийг хаагдуулдаг байна.

**2.5. Худалдааны тэнцлийн доройтол.** Пребиш-Зингерийн (Prebisch-Singer) таамаглал гэж нэрлэгддэг энэхүү үзэгдэл нь түүхий эдийн үнэ, үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүний үнээс удаан өсдөг гэсэн таамаглалд үндэслэдэг. Хэрэв аливаа эдийн засаг түүхий эд экспортолж олсон мөнгөөрөө бусад бараа бүтээгдэхүүн импортолдог болбол энэ нь тодорхой тоо хэмжээний бараа бүтээгдэхүүнийг импортолж хэрэглэхийн тулд улам их олборлолт хийх шаардлагатай болно гэсэн үг юм. Үүнийг шууд утгаар нь ойлгож хэрэгжүүлсэн импортыг орлуулах аж үйлдвэржилтийн бодлогууд удаа дараа нуран унаж байсан. Инфляцийн нөлөөг хассан бодит үнийн мэдээллийг ашиглан хийгдсэн сүүлийн үеийн судалгаанууд энэхүү үзэгдлийг дэмжих нотолгоо олдохгүй байгааг харуулж байгаа [25],[8].

<sup>12</sup> Гэхдээ олгогдсон зээлийн хүү нэлээн өндөр байх талтай байдаг (Hausman, Ribogon 2004).

<sup>13</sup> Эдийн засгийн хямралын үед сангийн болон мөнгөний тэлэх бодлого ихэвчлэн хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь илүү их хөрөнгийн эх үүсвэр хэрэгтэй гэсэн үг юм.

## Тэмдэглэл

1. 2008 оны тоо нь Үндэсний Статистикийн Хорооны (ҮСХ) 2008 оны эмхэтгэлээс, 1992, 1996 оны тоог ҮСХ-ны Статистик 80-жил эмхэтгэлээс авав. Бүгд оны үнээр, Уул уурхайн салбарын бүтээгдэхүүнд эрдэс бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийг оруулав.
2. ҮНБ-д эзлэх олборлох салбарын хувийг Хашчулуун et. al (2009)-ийн Уул уурхайн салбарын нийт экспортод эзлэх хувь хэмжээг IMF Financial Statistics-ийн ҮНБ-д эзлэх экспортын хувь хэмжээгээр үржүүлж гаргаж авсан.
3. Brunnschweiler and Bulte, 2008
4. Sachs and Warner, 1999
5. Kronenberg, 2004
6. Papyrakis and Gerlagh, 2007
7. Gylfason, 2001
8. Alexeev and Conrad, 2009
9. Oxfam, 2001
10. World Bank, 2003
11. World Bank, 2004
12. Atkinson and Hamilton 2003
13. Davies, et al, 2001
14. Quiros, Hassey, 1997
15. Leitte, Weidmann, 1999
16. Sala-i-Martin and Subrimanian, 2003
17. Ross, 2001
18. Collier and Hoffer, 2005
19. Humphreys et.al, 2007
20. Karl, 1997
21. Stiglitz, 2007
22. Mehlum et al., 2006
23. Gylfason, 2001
24. Birdsall, Pinkney, and Sabot, 2001
25. Harvey, Kellard, Madsen, Wohar, 2009.
26. Ross, 2004

## Ашигласан Материал

1. Alexeev, M., and Conrad, R. 2009. *The elusive curse of oil. Review of Economics and Statistics* хэвлэлтэнд байгаа,
2. Atkinson, G. and Hamilton, 2003. *Savings, growth and the resource curse hypothesis, World Development* 31(11), 1793-1807.
3. Birdsall, N., Pinkney, P. and Sabot, R. 2001. *Natural resources, human capital, and growth,* in R.M. Auty, ed., *Resource Abundance and Economic Development. Oxford: Oxford University Press*, pp. 57-75.
4. Brunnschweiler, C.N. and Bulte, E.H. 2008. *Linking natural resources to slow Growth and more conflict. Science* 320, 616-617.
5. Collier, P. and Hoffer, A. 2005. *Resource rents, governance and conflict. Journal of Conflict Resolution* 49, 625-633.
6. Davis, J., Ossowski, R., Daniel, J. and Barnett, S. 2001. *Stabilization and savings funds for non-renewable resources: experience and fiscal policy implications. IMF Occasional Paper* 205. IMF.
7. Gylfason, T. 2001. *Natural resources, education, and economic development, European Economic Review* 45, 847-859.
8. Harvey, D., Kellard, N., Madsen, J., Wohar, M. 2009. *The Prebisch-Singer hypothesis: four centuries of evidence, Review of Economics and Statistics*, хэвлэлтэнд байгаа,
9. Humphreys, M., Sachs, J.D. and Stiglitz, J.E. 2007. *Escaping the Resource Curse. Columbia University Press*,
10. Karl, T.L. 1997. *Paradox of Plenty: oil booms and petro states. University of California Press*,
11. Kronenberg, T. 2004. *The curse of natural resources in transition economies. Economics of Transition* 12(3), 399-426.
12. Lette, C. And Weidmann, J. 1999. *Does mother nature corrupt? Natural resources, corruption, and economic growth. IMF working paper WP/99/85*,
13. Ч.Хашчулуун, С.Дөлбадрах, Б.Ариун-Эрдэнэ, Д.Баярмаа, Ж.Үнэнбат, Ц.Батсүх, Г.Банзрагч, Н.Энхбаяр, Д.Бямбасүрэн, Б.Мөнхсөёл. 2009. *Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний тойм: Эдийн засаг дахь төрийн оролцоо. Sodpress* 2009,
14. Үндэсний Статистикийн Газар 2004. *Статистик-80 жил, Улаанбаатар*,
15. Үндэсний Статистикийн Хороо 2008. *Статистикийн Эмхэтгэл*.
16. Mehlum, H., Moene, K. and Torvik, R. 2006. *Institutions and the resource curse. Economic Journal* 116, 1-20,
17. Oxfam (2001). *Extractive sectors and the poor: An Oxfam Report. Boston: Oxfam America (prepared by Ross, M.L)*,
18. "Oil firm ELF accused of bribing African officials" 2001. *Inter-Press Service, November* 22,
19. Papyrakis, E., and Gerlagh, R. 2007. *Resource abundance and economic growth in the United States. European Economic Review* 51, 1011-1039,
20. Ross, M. 2001. *Timber Booms and Institutional Breakdown in Southeast Asia. New York: Cambridge University Press*,
21. Ross, M. 2004. *Does taxation lead to representation? British Journal of Political Science* 34, 229-249,
22. Quiros, Hassey 1997. *Copper, futures, Codelco: an econometrics perspective, Revista de Analisis Economico* 12 (1), 63-84,
23. Sachs, J., and Warner, A. 1997. *Natural resource abundance and economic growth. Revised Version. Harvard Institute for International Development, Cambridge, MA*,
24. Sachs, J., and Warner, A. 1999. *The big push, natural resource booms and growth, European Economic Review* 59, 43-76,
25. Sala-i-Martin, X. and Subrimanian, A. 2003. *Addressing the natural resource curse: an illustration from Nigeria. NBER working paper* 9804,
26. Stiglitz, J.E. 2007. *What is the role of the state? In Humphreys, et. al. eds. Escaping the Resource Curse. Columbia University Press*,
27. World Bank. 2003. *Striking a better balance. Final Report of the Extractive Industries Review, December*,
- World Bank. 2004. *World Bank Group Management Response on Striking a better balance. Final Report of the Extractive Industries Review, September*